



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.04.12 № 03/2595

танай _____ -ны № _____ -т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан ТБ/20240202118 дугаартай “Ханшийн самбар” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Эм Ди даян” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалтын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Эм Ди даян” ХХК-ийн гомдолд тус компанийн тендерээс нийлүүлэх барааны үйлдвэрлэгчийн албан ёсны борлуулагчийн гэрчилгээ ирүүлээгүй гэж татгалзсан захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй, мөн захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Өү Юу Эйч” ХХК-ийн тендерийн маягт 1-д тендер хүчинтэй байх хугацаа 45 хоног байгаа нь ажлын 30-аас дээш өдөр байх шаардлагад нийцэхгүй, маягт 3-т гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил хэсэг илэрхийлэлгүй, тодорхойгүй, тендерт хувилбарт санал ирүүлсэн байж болзошгүй, үйлдвэрлэгчийн албан ёсны борлуулагчийн гэрчилгээний орчуулга ирүүлээгүй бөгөөд тухайн гэрчилгээ тамга, тэмдгээр баталгаажаагүй, гэрчилгээний хугацаа дууссан байж болзошгүй, санал болгосон барааны техникийн тодорхойлолт нь тендер шалгаруулалтын баримт бичгийн техникийн тодорхойлолтод заасан “аль нэг зүйл заалтыг орхигдуулахгүй байх ба тоон үзүүлэлтийг дурдахгүйгээр зөвхөн “болно”, “тийм”, “хангасан”, “нийцнэ” гэх зэрэг үгсээр хүснэгтийг бөглөсөн тохиолдолд харьцуулсан ирүүлсэнд тооцохгүй” гэх шаардлага хангахгүй байх тул захиалагчийн шийдвэрийг хянан үзэхийг хүссэн байна.

I. Гомдолд дурдсаны дагуу “Эм Ди даян” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2-т “11. Бараа бүтээгдэхүүн нийлүүлэх үйлдвэрлэгчийн албан ёсны борлуулагчийн гэрчилгээний хуулбар ирүүлнэ.” гэж заасан байна.

“Эм Ди даян” ХХК тендерт “Саммит компьютер технологи” ХХК-д “Haier singapore investment holding pte” компаниас 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр олгосон албан ёсны борлуулагч болон засвар үйлчилгээний гэрчилгээ, “Саммит компьютер технологи” ХХК-аас “Эм Ди даян” ХХК-д олгосон 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 09-140 тоот гэрээт борлуулагчийн итгэмжлэл тус тус ирүүлснийг

дээрх шаардлагад нийцэхгүй гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

II. Гомдолд дурдсаны дагуу захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Өү Юу Эйч” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1. Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 2.13-т “Оролцогчоос ирүүлсэн тендер энэ журмын 2.3.6-д заасны дагуу цахим системийн холбогдох талбарт оруулсан мэдээлэлтэй зөрвөл цахим системийн мэдээллийг баримтална.” гэж, тендер шалгаруулалтын баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 14.1-д “IV бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.” гэж тус тус заасан.

Худалдан авах ажиллагааны цахим системд “Өү Юу Эйч” ХХК-ийн ирүүлсэн тендер илгээх маягт (маягт 1)-д “5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш ажлын 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.” гэж заасан байх тул энэ тухай гомдол үндэслэлгүй байна.

2. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 15.1-д “Хувилбарт санал ирүүлэхийг: Зөвшөөрөхгүй.” гэж заасан байна.

“Өү Юу Эйч” ХХК-ийн санал болгосон тендерийн үнэ 67,650,000.0 төгрөг, барааны үнийн задаргаанд тендерийн нийт үнэ 67,650,000.0 төгрөг гэж тус тус ирүүлсэн байх тул тус компанийн тендерийн үнийн задаргааны 8, 9 дэх баганыг бөглөөгүй байгааг хувилбарт санал ирүүлсэн гэх гомдол үндэслэлгүй байна.

Тендерийн шалгаруулалтын баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 22.4-т “Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.” гэж заасан тул тус компанийн санал болгосон тендерийн үнэд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан нөхцөлөөр гэрээний үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай татвар, даатгал, тээвэрлэлтийн болон бусад бүх зардлыг тендерийн үнэд багтсан гэж үзэхийг анхаарна уу.

3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Ижил төстэй гэрээний туршлага: Шаардана. 2022, 2023 онуудын гэрээний үнийн дүнгийн нийлбэр нь батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа хүлээлгэн өгсөн байна. Гэрээний хуулбар ирүүлнэ. Гэрээний үүргээ биелүүлсэн тухай захиалагчийн тодорхойлолт эсхүл гэрээ дүгнэсэн акт /бараа хүлээлцэн акт/-ыг ирүүлнэ.” гэж заасан байна.

“Өү Юу Эйч” ХХК тендерт Төрийн банктай 2023 онд байгуулсан 16/08 дугаартай “Салбар тооцооны төвүүдэд шаардлагатай ханшийн самбар” нийлүүлэх гэрээ ирүүлсэн байх ба тухайн ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл (маягт 3)-д гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршилын мэдээллийг бөглөөгүй боловч дээрх гэрээнд гэрээ гүйцэтгэсэн байршилын мэдээлэл тодорхой тусгагдсан байх тул тус мэдээллийг маягтад бөглөж ирүүлээгүй нь шаардлагад нийцэхгүй гэх гомдол үндэслэлгүй байна.

4. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 12.2-т “Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл” гэж, ТШЗ 19.2-т “11. Бараа бүтээгдэхүүн

нийлүүлэх үйлдвэрлэгчийн албан ёсны борлуулагчийн гэрчилгээний хуулбар ирүүлнэ." гэж заасан байна.

"Өү Юу Эйч" ХХК-ийн тендерт хавсаргасан үйлдвэрлэгчийн албан ёсны гэрчилгээ гэх баримтын орчуулга ирүүлээгүй байхад дээрх шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

Тус компанийн тендерт ирүүлсэн үйлдвэрлэгчийн албан ёсны гэрчилгээ гэх баримт тамга, тэмдэггүй бөгөөд уг гэрчилгээний хугацаа дуусгавар болсон эсэхийг гомдлын хүрээнд хянан боломжгүй болохыг дурдах нь зүйтэй байна.

5. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2-т "3. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр үзүүлэлтүүдийг харьцуулсан хүснэгт бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ. Аль нэг зүйл заалтыг орхигдуулаагүй байх ба тоон үзүүлэлтүүдийг дурдахгүйгээр зөвхөн "болно", "тийм", "хангасан", "нийцнэ" гэх зэрэг үгсээр хүснэгтийг бөглөсөн тохиолдолд харьцуулсан хүснэгт ирүүлсэнд тооцохгүй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд тухайн тендерээс татгалзана." гэж, техникийн тодорхойлолтод "Ногоон худалдан авалтын шаардлага: 1.А+ үзүүлэлтээс дээш эрчим хүчний хэмнэлттэй. 2.Эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй. 3.Дахин боловсруулсан түүхий эдээр хийсэн" заасан байна." гэж тус тус заасан байна.

"Өү Юу Эйч" ХХК санал болгож байгаа тендерийн техникийн тодорхойлолтод барааны үзүүлэлтийг тусган ирүүлсэн боловч тендер шалгаруулалтын баримт бичгийн техникийн тодорхойлолтод заасан "ногоон худалдан авалтын шаардлага"-ыг хангах нотлох баримтыг ирүүлээгүй байхад дээрх шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 17/1749 болон гэрээ байгуулах эрх олгосон 17/1750 тоот шийдвэрийг тус тус хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 55.10.3 дахь заалтад үндэслэн тендер шалгаруулалтын тендерийн үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: "Эм Ди даян" ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Ж.ГАНБАТ